



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 06 дугаар хуралдааны мэдээлэл

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 06 дугаар хуралдааныг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) зохион байгуулав.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны (5G) сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төслийн тухай (Хорооны 2022 оны ээлжит 5 дугаар хуралдаанаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын тухай; Тэмдэглэл-07, 2022 он); Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаар танилцуулга; "Улаанбаатар, орон нутгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт хийсэн мониторингийн тайлан" танилцуулга (2022 оны эхний 5 сарын байдлаар); Тусгай зөвшөөрлийн талаар үнэлгээ, дүгнэлтийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох тухай, тусгай зөвшөөрөл сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах, шилжүүлэх, хүчингүй болгох тухай) зэрэг 6 асуудлыг тус тус хэлэлцэж, хорооны хуралдааны 5 тогтоолыг баталж, хуралдааны 1 тэмдэглэлээр бүтцийн нэгжийн удирдлагад хугацаатай үүрэг даалгавар, удирдамж чиглэлийг өгсөн болно.

Зохицуулах хорооны 2022 оны 07 дугаар хуралдааны /2022-05-26/ тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар, удирдамж чиглэлийг тус хорооны РДЗХГ-аас Дараа үеийн хөдөлгөөнт холбооны (5G) сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төсөлд оруулсан зарим зүйл, заалтын найруулга, нэмэлт өөрчлөлт оруулсан заалт, шинээр нэмсэн заалтыг тусгасан тухай танилцуулга, нэмэлт өөрчлөлт оруулсан баримт бичгийн хэлэлцүүлгийн үр дүн, оролцогч талуудын зөвшилцсөн зүйл, заалтын нэмэлт тайлбар, мэдээллийн хамт 2022 оны ээлжит 06 дугаар хуралдаанд танилцуулав. Энэхүү хуралдааны үеэр хорооны дарга, гишүүдээс баримт бичгийн төслийн дахин хэлэлцүүлгийн үеэр үйлчилгээ эрхлэгч нар, эрх ашиг нь хөндөгдөж байгаа хуулийн этгээд нараас гарсан саналыг уулзалтын протокол болон албан тоотоор албажуулж авч баримт бичигт эцэслэн тусгах, Дараа үеийн хөдөлгөөнт холбооны зурвасын хуваарилалт, зохицуулалтын талаар ОУЦХБ-аас баталсан ба батлахаар төлөвлөж буй зарчмын баримт бичиг, зөвлөмжүүд, Монгол улсад Дараа үеийн хөдөлгөөнт холбооны шилжилтийг дэмжих зохицуулалтын арга хэмжээг холбогдох журам, нөхцөл шаардлагад тусгах, уялдуулаа нийцлийг хангах, арга хэмжээг төлөвлөх талаар анхаарах /төлбөрийн хөнгөлөлт, эрхийн төлбөр г.м/, үүрэн холбооны 2G, 3G дах сүлжээ, хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, түүний цаашдын чиг хандлага, туршлагыг судлан баримт бичгийн төслийг хорооны хуралдаанд 2022 оны 03 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэхийг холбогдох газар, хэлтэст даалгав.

ХХЗХ-ны 2022 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар "Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаар танилцуулга"; "Улаанбаатар, орон нутгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт хийсэн мониторингийн тайлан" танилцуулга (2022 оны эхний 5 сарын байдлаар) мэдээллийг тус тус сонсов. Хуралдаанаар сонссон баталгаажуулалтын үйл

ажиллагааны талаар танилцуулга, өргөн нэвтрүүлгийн мониторингийн тайлан мэдээллийг сар бүр байгууллагын цахим хуудас, улирал бүр гэрээт сайтаар байршуулж олон нийт, үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгч нарт нээлттэй болгох, үр дүнг сурталчлах, улирлын тайланг хугацаатай үүргийн хамт албан тоотоор холбогдох ААН, хуулийн этгээдэд хүргүүлэх, үндэсний болон салбарын бодлого, зохицуулалтын уулзалт семинар, сургалтад дэлгэрэнгүй байдлаар танилцуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулахыг холбогдох газар хэлтсүүдэд үүрэг болгов.

Тус хуралдааны "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төслийн тухай асуудлыг хэлэлцэх үеэр хорооны нэр бүхий гишүүдээс гарсан саналын дагуу хорооны гишүүдийг олон улсын болон салбарын хөгжлийн бодлого зохицуулалт, цахим орчин, өрсөлдөөн, техник технологи, сүлжээ, ашиглалт үйлчилгээний зохицуулалтын орчин, зохицуулалтын үндсэн зарчим, арга механизмууд, цаашдын чиг хандлага, тэргүүн туршлага, хувилбар шийдлийн талаар мэдээллээр хангах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор цахим хөгжил, харилцаа холбоо, мэдээллийн технологи, аюулгүй байдал, өргөн нэвтрүүлэг, шуудан холбооны сүлжээ, техник технологи, үйлчилгээний зохицуулалт, цаашдын хөгжлийн чиг хандлагууд, Монгол Улсын гишүүнчлэл бүхий НҮБ-ын төрөлжсөн, салбарын олон улсын болон бүс нутгийн байгууллагын бодлого шийдвэр, зохицуулалтын чиглэлээр олон талт, хоёр талын хамтын ажиллагаа, зохицуулалт ба өрсөлдөөний орчны өөрчлөлт, жишиг улс орны тэргүүн туршлага, хөгжлийн үе шат, технологийн дэвшлийн чиг хандлагууд зэрэг асуудлаар танилцуулга, мэдээлэл тайлан боловсруулж, Хорооны ээлжит, ээлжит бус хуралдаанд тухай бүр хэлэлцүүлэх, танилцуулж ажиллахыг хариуцсан газар, хэлтэст тус тус үүрэг болгож, энэхүү үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д даалгав.

Хорооны 2022 оны ээлжит 06 дугаар хуралдаанаар "Тусгай зөвшөөрөл олгох тухай", "Тусгай зөвшөөрөл сэргээх тухай", "Тусгай зөвшөөрөл шилжүүлэх тухай", "Тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай", Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай" холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 27 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дах хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 6 дугаар зүйлийн 6.6 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 28 тоот тогтоолын хавсралтаар 8 хуулийн этгээдийн 8 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан

“Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.6, 5.7 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 29 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн;

- Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дах заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалт болон 5.3 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 30 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 31 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдийн 7 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2022-06-26